



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/469

Арвайхээр


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны "БҮТЭЭЛЧ ӨВӨРХАНГАЙ-2020" хөтөлбөрийн 3.3.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймгийн Гучин-Ус сумын харьяат Монгол Улсын дархан мэргэн Лодойн Бадарчин агсны нэрэмжит 2020 оны үндэсний шагайн харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээний шагналын зардалд 1,760,000 (нэг сая долоон зуу жаран мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх 1,760,000 (нэг сая долоон зуун жаран мянга) төгрөгийн зардлыг аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011101039